



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Баян-Ойт бага сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/12/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.18 № 2/28

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\alban bichig\A4.docx




005020255

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular stamp. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТ АГУУГА" (State Audit Agency of Mongolia) and a logo. The signature is written in a cursive style, crossing the stamp.

Б.МӨНХБАТ

Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,173,600,154.74	2,145,752,748.63
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	808,006,480.00	790,311,838.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,251,676.00	1,232,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,251,676.00	1,232,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,251,676.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,251,676.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	159,965,104.00	167,736,838.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	640,789,700.00	621,342,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,882,404.00	27,929,203.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,882,404.00	27,929,203.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,082,700.00	139,807,635.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,082,700.00	139,807,635.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	810,855,292.10	818,011,444.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	810,855,292.10	818,011,444.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	738,232,767.84	767,040,411.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,170,284.93	473,028,926.10
210101	Үндсэн цалин	342,017,162.27	410,633,926.10
210102	Нэмэгдэл	51,636,127.87	40,176,700.00
210104	Урамшуулал	60,516,994.79	22,218,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,740,000.00	59,823,813.69
210201	Тэтгэврийн даатгал	43,319,600.00	48,086,413.69
210202	Тэтгэмжийн даатгал	4,605,100.00	2,934,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,684,100.00	2,347,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	921,000.00	586,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,210,200.00	5,868,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,855,741.00	125,677,635.00
210301	Гэрэл, цахилгаан	349,400.00	5,918,194.00
210302	Түлш, халаалт	114,691,005.00	114,691,005.00
210303	Цэвэр, бохир ус	5,815,336.00	5,068,436.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,596,265.82	21,416,493.79
210401	Бичиг хэрэг	4,161,950.00	5,962,502.51
210402	Тээвэр, шатахуун	1,709,000.00	300,587.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,552,299.81	911,121.06
210404	Ном, хэвлэл	1,411,000.00	90,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ариутгал	1,400,200.00	730,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	311,900.00	11,707,420.00
210408	Бараа материал акталсны зардал	33,049,916.01	1,714,863.00
2105	Нормативт зардал	2,687,618.00	9,498,961.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,687,618.00	9,498,961.00




Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,902,950.00	8,841,400.00
210604	Урсгал засвар	1,902,950.00	8,841,400.00
2107	Томилолт, зочны зардал	66,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	66,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	554,000.00	8,150,963.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	304,000.00	8,010,713.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	140,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,659,908.09	60,602,219.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	996,000.00	43,495.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,128,000.00	1,369,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	49,535,908.09	59,188,924.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,622,524.26	50,971,032.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,950,619.00	47,458,425.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,795,215.00	30,125,835.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,519,424.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,362,980.00	17,232,590.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,273,000.00	100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	81,251.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,251.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,590,654.26	3,512,607.58
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,590,654.26	3,512,607.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-2,848,812.10	-27,699,606.54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,124,964.63	143,399.57
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,124,964.63	143,399.57
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7,124,964.63	-143,399.57
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-9,973,776.73	-27,843,006.11

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	800,754,804.00	789,079,138.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	800,754,804.00	789,079,138.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	640,789,700.00	621,342,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,882,404.00	27,929,203.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,882,404.00	27,929,203.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,082,700.00	139,807,635.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,082,700.00	139,807,635.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	771,643,240.00	774,317,738.00



Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	771,643,240.00	774,317,738.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	702,298,320.74	723,609,355.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	456,402,631.93	471,048,200.00
210101	Үндсэн цалин	344,249,509.25	391,092,500.00
210102	Нэмэгдэл	51,636,127.89	49,914,100.00
210104	Урамшуулал	60,516,994.79	30,041,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,740,000.00	62,535,916.36
210201	Тэтгэврийн даатгал	43,319,600.00	47,022,616.36
210202	Тэтгэмжийн даатгал	4,605,100.00	3,878,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,684,100.00	3,102,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	921,000.00	775,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,210,200.00	7,756,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,449,449.00	125,677,635.00
210301	Гэрэл, цахилгаан	349,400.00	5,918,194.00
210302	Түлш, халаалт	116,284,713.00	114,691,005.00
210303	Цэвэр, бохир ус	5,815,336.00	5,068,436.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,025,749.81	13,783,251.06
210401	Бичиг хэрэг	1,962,000.00	1,646,000.00
210402	Тээвэр, шатахуун	609,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,552,299.81	704,641.06
210404	Ном, хэвлэл	910,000.00	90,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,400,200.00	817,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,592,250.00	9,525,610.00
2105	Нормативт зардал	6,556,940.00	13,565,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,671,940.00	9,965,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,885,000.00	3,600,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,208,550.00	20,130,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	680,000.00	00.00
210604	Урсгал засвар	15,528,550.00	20,130,000.00
2107	Томилолт, зочны зардал	66,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	66,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	554,000.00	8,248,753.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	304,000.00	8,010,713.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	238,040.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,295,000.00	8,619,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,857,000.00	6,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,438,000.00	1,719,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,344,919.26	50,708,382.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,673,014.00	47,195,775.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,517,610.00	29,863,185.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,519,424.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,362,980.00	17,232,590.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,273,000.00	100,000.00



Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	81,251.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,251.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,590,654.26	3,512,607.58
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,590,654.26	3,512,607.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	29,111,564.00	14,761,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,111,564.00	14,761,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,111,564.00	14,761,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,111,564.00	14,761,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,111,564.00	14,761,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-29,111,564.00	-14,761,400.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	72,299,096.87	208,661,254.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	72,299,096.87	208,661,254.77
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,771,797.23	-2,771,797.23
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,037,233,596.84	2,173,595,754.74
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,037,233,596.84	2,173,595,754.74
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,037,233,596.84	2,173,595,754.74
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-27,843,006.11	-27,843,006.11
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,009,390,590.73	2,145,752,748.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	778,346,300.00	757,637,327.42	20,708,972.58	97.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	778,346,300.00	757,637,327.42	20,708,972.58	97.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	748,220,500.00	727,674,142.42	20,546,357.58	97.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471,048,200.00	471,048,200.00	0.00	100.00



Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	391,092,500.00	391,092,500.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	49,914,100.00	49,914,100.00	0.00	100.00
210104	Урамшуулал	30,041,600.00	30,041,600.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,542,400.00	62,535,916.36	6,483.64	99.99
210201	Тэтгэврийн даатгал	47,029,100.00	47,022,616.36	6,483.64	99.99
210202	Тэтгэмжийн даатгал	3,878,300.00	3,878,300.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,102,700.00	3,102,700.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	775,700.00	775,700.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,756,600.00	7,756,600.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,004,000.00	125,677,635.00	16,326,365.00	88.50
210301	Гэрэл, цахилгаан	7,178,900.00	5,918,194.00	1,260,706.00	82.44
210302	Түлш, халаалт	127,045,100.00	114,691,005.00	12,354,095.00	90.28
210303	Цэвэр, бохир ус	7,780,000.00	5,068,436.00	2,711,564.00	65.15
2104	Хангамж, бараа материалын зардал	16,676,200.00	14,944,751.06	1,731,448.94	89.62
210401	Бичиг хэрэг	1,501,600.00	1,646,000.00	-144,400.00	109.62
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	1,000,000.00	-700,000.00	333.33
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,019,600.00	704,641.06	1,314,958.94	34.89
210404	Ном, хэвлэл	1,288,300.00	651,500.00	636,800.00	50.57
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,517,000.00	817,000.00	700,000.00	53.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,049,700.00	10,125,610.00	-75,910.00	100.76
2105	Нормативт зардал	14,968,600.00	13,565,800.00	1,402,800.00	90.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,359,900.00	9,965,000.00	1,394,900.00	87.72
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,608,700.00	3,600,800.00	7,900.00	99.78
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,924,700.00	30,030,000.00	894,700.00	97.11
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,900,000.00	9,900,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	21,024,700.00	20,130,000.00	894,700.00	95.74
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,254,000.00	1,252,040.00	1,960.00	99.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,014,000.00	1,014,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	238,040.00	1,960.00	99.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8802400.00	8619800.00	182,600.00	97.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,900,000.00	6,900,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,902,400.00	1,719,800.00	182,600.00	90.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30125800.00	29963185.00	162,615.00	99.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,125,800.00	29,963,185.00	162,615.00	99.46

Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,865,100.00	29,863,185.00	1,915.00	99.99
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	260,700.00	100,000.00	160,700.00	38.36
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	778,346,300.00	757,637,327.42	20,708,972.58	97.34
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	621,342,300.00	617,829,692.42	3,512,607.58	99.43
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	621,342,300.00	617,829,692.42	3,512,607.58	99.43
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	157,004,000.00	139,807,635.00	17,196,365.00	89.05
132001	Орон нутгийн төсвөөс	157,004,000.00	139,807,635.00	17,196,365.00	89.05
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	38.00	38.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	26.00	26.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	0.00	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	596.00	596.00	35.00	94.13
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	596.00	596.00	0.00	#DIV/0!
630001	Төрийн өмчит ЕБС	596.00	596.00	0.00	#DIV/0!
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	38.00	0.00	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	27.00	27.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,882,404.00	27,929,203.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,882,404.00	27,929,203.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		10,696,613.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,696,613.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,696,613.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,882,404.00	1723290.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,882,404.00	1,723,290.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,519,424.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,632,980.00	17,232,590.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,882,404.00	27929203.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,882,404.00	27,929,203.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,882,404.00	27,929,203.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Баян-Ойт бага сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 1/56 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд сургуулийн захирал Л.Аюурзана нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Ж.Амаржаргал нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын Баян-Ойт бага сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тус сургууль нь “Багш бүр хүүхдийн өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжиж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан, сурах үйлийн таатай орчныг бүрдүүлэн агуулгын хоцрогдлыг арилгаж, хичээлийн цахим санг бий болгоно” .

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/37 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 812,875.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,193.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,144.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 9,202.6 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,145,572.7 мянган төгрөг болж өмнөх оноос 27,847.4 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	85,021.70	91,795.30	6,773.60
Мөнгөн хөрөнгө	-	-	0.00
Авлага	-	-	0.00
Урьдчилгаа	-	-	0.00
Бараа материал	75,013.30	91,008.90	15,995.60
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,088,578.30	2,053,957.40	-34,620.90
Үндсэн хөрөнгө	2,264,237.80	2,287,477.20	23,239.40
Хуримтлагдсан элэгдэл	-175,659.50	-233,519.80	-57,860.30
Нийт хөрөнгө	2,173,600.10	2,145,752.70	-27,847.40
Өр төлбөр	0	0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,173,595.70	2,145,752.70	-27,843.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,173,595.70	2,145,752.70	-27,843.00

Бараа материалын дансны үлдэгдэл 91,008.9 мянган төгрөг болж 15,995.0 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал дансны үлдэгдэл өмнөх оноос 24,435.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба Дээд шатны төсөв захирагчаас шилжүүлж ирсэн 1,232.7 мянган төгрөгийн халдвар хамгааллын хэрэгслийг орлогоор авсан нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,287,477.2 мянган төгрөг болж 23,239.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 14,761.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271-р тогтоолын 4.1.1-д заасны дагуу холбогдох дансанд орлогоор бүртгэсэн ба өмнөх оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн 9,950.0 мянган төгрөгийн ухаалаг самбарыг тус тус холбогдох дансанд орлогоор бүртгэж 1,472.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Тайлант онд 786,3 мянган төгрөгийн авлага үүссэн нь биеийн тамирын багш Х.Дэлэгпилийн цалинг нягтлан бодогч 1,159.6 мянган төгрөгөөр 2020 оны 7-р сард мэдээлсэн байхад Нийгмийн даатгалын цахим системд тухайн албан тушаалтны цалинг дахин давтан 2,319.3 мянган төгрөг болж давхар орсон байсныг 2021 оны жилийн эцэст тооцоо нийлж тус алдааг залруулснаас НДШ-ийн авлага 214.5 мянга, ХАОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтийн тооцооллын алдааны улмаас ХАОАТ-ын авлага 571.8 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэл тайланд тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,145,752.7 мянган төгрөг болж 27,843.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 27,843.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 736,349.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 736,349.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 35,337.7 мянган төгрөгөөр бууруулж 701,012.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийгдэж 778,346.3 мянган төрөг болж 77,334.3 мянган төгрөг буюу 9.9 хувиар өсөж батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 778,346.3 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 621,342.3 мянга, орон нутгийн төсвөөс 157,004.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 621,342.3 мянга, орон нутгийн төсвөөс 139,807.6 мянга нийт 761,149.9 санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 757,637.3 мянган төгрөгийг зарцуулж 3.512,6 мянган төгрөг буюу 0.4 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Харин орон нутгийн төсвийн санхүүжилтийг 17,196.3 сая төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу санхүүжүүлсэн байгаа нь төсвийг гүйцэтгэлтэй нь уялдуулан олгосонтой холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 757,637.3 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь байр ашиглалттай тогтмол зардлыг 16,326.3 мянга, НДШ-ын зардлыг 1,731.4 мянга, урсгал засварын зардлыг 894,7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 182.6 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 160.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 100032015405 тоот дансанд БСУГ-аас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 17,232.5 мянга, Тэтгэлэгт хөтөлбөрийн уралдааны шагналын мөнгө 10,600.0 мянга, шалгалтын бичиг хэргийн зардалд 96.6 мянга нийт 27,929.2 мянган төгрөгийг олгосон бөгөөд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад олгодог 5 жилийн тэтгэмж урамшууллын зардалд 17,232.5 мянга, принтер худалдан авах зардалд 2,499.9 мянга, шагнал урамшууллын зардалд 3,276.0 мянга, сургалтын зардалд 2,698.1 мянга, бичиг хэргийн зардалд 1022.6 мянга, номын зардалд 1,200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Г.Ганчимэг санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 53 ажлыг төлөвлөж, хэрэгжилт 88%-тай гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 818,011.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 7,156.2 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хангамжийн материал өмнөх оноос буурсан бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн системд нийт 778,346.3 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг хугацаандаа байршуулж, 7-р сард

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	94	2	0
	Нийт	27	151	147	2	2

74,673.7 мянган төгрөгийн Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягаар мэдээлэл, 9-р сард 54,946.4 мянган төгрөгийн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр байршуулах

мэдээлэл нийт 2 төрлийн 131,620.1 мянган төгрөгийн мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Урсгал төсвийн зарцуулалт нь гүйцэтгэлээр улсын төсвөөс 621,342.3 мянга, орон нутгийн төсвөөс 139,807.6 мянга нийт 761,149.9 санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 757,637.3 мянган төгрөгийг зарцуулж 3.512,6 мянган төгрөг буюу 0.4 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Мөн орон нутгийн төсвөөс тогтмол зардлын санхүүжилт 157,001.0 мянган төгрөг батлагдаж 139,807.6 мянган төгрөгийн олгож төлөвлөгөөнөөс 17,196.3 мянган төгрөг буюу 12.3 хувийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Үүнээс үзэхэд нийт 20,708.9 мянган төгрөг буюу 12.7 хувийн хэмнэлт гарсан байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд бүрэн нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,577.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 10,009.0 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж хэрэгжилтийн тайланг 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах аяны хүрээнд шалгасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,384.6 мянган төгрөгийн алдаа илэрч зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлээ.

4.2 Зөвлөмж

4.2.1 Санхүүгийн бараа материалын тодруулга тайлан болон нярвын тайлангийн үлдэгдлээр Барилгын засварын материал дансанд 6384,6 мянган төгрөгийн Акустик хавтан, вакум хаалт, угаалтуур, угаагуур, шатны хамгаалалт резин зэрэг материалыг зориулалтын дагуу зарцуулсан боловч тайланд зарлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.6. бүх зардал гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Зарцуулсан атлаа үлдэгдлээр тусгасан бараа материалыг холбогдох хууль журмын дагуу шийдвэр гаргаж данс бүртгэлээс хасах зөвлөмж өгөв.

4.2.2 Шилэн дансны нэгдсэн системд нийт 778,346.3 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг хугацаандаа байршуулж, 7-р сард 74,673.7 мянган төгрөгийн Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягаар мэдээлэл, 9-р сард



Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

54,946.4 мянган төгрөгийн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр байршуулах мэдээлэл нийт 2 төрлийн 131,620.1 мянган төгрөгийн мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.4, 6.4.5 дахь хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын сургууль, цэцэрлэгийн Баян-Ойт цогцолбор	2	6,384.6	0	0	0	0	0	0	2	6,384.6

_____оОо_____